



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 8/30

Бор-өндөр сум

**Ур чадварын
нэмэгдэл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Нэгдсэн эмнэлгийн даргын 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/30 тоот тушаал, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ;

1. Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 02 дугаар сарын ур чадварын нэмэгдэл олгох ажилчдын нэрс, урамшууллын хэмжээг нэгдүгээр хавсралтаар, ур чадварын нэмэгдэл олгох үндэслэл, үнэлгээний хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хавсралтаар баталсан ажилчдын мөнгөн урамшууллыг зохих журмын дагуу бодож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дарга (Б.Энхмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАТБААТАР

